



МҮХАҮТ-ЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

МҮХАҮТ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2024-2027

1. Бизнесийн орчныг сайжруулах

- Эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, төрийн оролцоог бууруулах хууль эрх зүйн орчныг сайжруулах,
- Эдийн засгийн гол салбаруудын урт болон дунд хугацааны бодлогыг шинэчлэх, боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог хангах,
- Бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль эрх зүйн зохицуулалтуудыг сайжруулах,
- Төр, хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэлийг нэмэгдүүлэх,

2. Бодлогын өмгөөллийг сайжруулах

- Аж ахуйн нэгжүүд, эдийн засгийн гол салбаруудын нийтлэг бодлогын зорилго, зорилтуудыг тодорхойлж, эрх зүйн орчны нөхцөл байдлын судалгаан дээр үндэслэн шаардлагатай бодлогын өмгөөллийг хэрэгжүүлэх, холбогдох бүтцүүдийг бий болгох,
- Хууль тогтоогч, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, судлагааны байгууллагууд, судлаачид, олон нийт зэрэг гол оролцогч талуудтай сайн харилцаа тогтоож, үр дүнтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлэх,
- Бодлогын өмгөөллийн чадавхиа сайжруулах,
- Бизнесийн төлөөллийн байгууллагуудын хууль эрх зүйн орчин, хамтын ажиллагааг сайжруулах,

3. Компани хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

- Аж ахуйн нэгжүүдийн нийтлэг эрх ашиг, сонирхол дээр тулгуурласан арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, харилцан суралцах, мэдээлэл, туршлага солилцох боломжуудыг бий болгох,
- Хүний нөөц бэлдэж, сургахад хамтран ажиллах боломжуудыг бий болгох,
- Хамтарсан хөрөнгө оруулалт, судалгааны төслүүд болон хамтран ажилласнаар зардал бууруулах, өгөөж, бүтээмж нэмэгдүүлэх санал санаачилгуудыг дэмжин, аж ахуйн нэгжүүдийг холбон ажиллах,

4. Компаниудын нийгмийн хариуцлагыг сайжруулах

- Аж ахуйн нэгжүүдийг бизнесийн ёс зүй, компанийн засаглалаа сайжруулахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх,
- Нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдэх аж ахуйн нэгжүүдийн санал, санаачилгуудыг нэгтгэн уялдуулж, хамтрах ажлыг зохион байгуулах,

МҮХАҮТ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Бодлогын өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргах

- 1.1 Худалдаа аж үйлдвэрийн танхимын хуулийн шинэчлэлийг хийх,
- 1.2 УИХ-ын 2024 оны сонгуульд орох намуудын мөрийн хөтөлбөрт хувийн хэвшил, аж ахуй эрхлэлтийг дэмжих саналуудыг бэлтгэн хүргүүлэх,
- 1.3 Татварын ачааллыг бууруулах, шударга хуваарилах, татварын суурийг нэмэгдүүлэх, төлсөн татварын зарцуулалтанд хяналт тавих бололцоог хангах, нийтийн санхүүгийн хяналт, зохицуулалтыг сайжруулахад чиглэсэн татварын шинэчлэлийн саналыг бэлтгэж танилцуулах,
- 1.4 Бизнесийн орчинд хүндрэл бэрхшээл учруулж буй хууль эрх зүйн акт, зохицуулалт, төрийн үйлчилгээтэй холбоотой саналыг хүлээн авах цахим тогтолцоог бий болгох, ирүүлсэн саналуудыг нэгтгэн дүн шинжилгээ хийж, холбогдох шийдлүүдийг гарган эрх бүхий байгууллагуудтай ажиллах,
- 1.5 Бизнесийн орчинд нөлөөлөх хууль эрх зүйн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтүүдийг хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулах үед нь оролцон санал оруулах бүтцийг бий болгох,
- 1.6 Бизнесийн нийтлэг болон тухайлсан салбарын асуудлуудаар хамтран хэлэлцэх, байр сууриа нэгтгэж илэрхийлэх зохистой бусад бүтэц зохион байгуулалтыг дэмжих, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох,
- 1.7 Аж ахуйн нэгжүүдтэй ойрхон ажиллаж нийтлэг хэрэгцээ, шаардлагыг илүү таньж мэддэг болох,
- 1.8 Хувийн хэвшлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийн талаар зөв ойлголтыг олон нийтэд өгөх контент хийж түгээх,

2. Бизнесийн боломжуудыг нэмэгдүүлэх, таатай хууль эрх зүйн орчныг бий болгох, аж ахуйн нэгжүүд хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах

- 2.1 Төрийн өмч, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн оролцох шаардлагагүй эдийн засгийн салбаруудыг тодорхойлон, холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх,
- 2.2 Эдийн засагт чухал ач холбогдолтой томоохон төсөл хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх чиглэлээр уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулах, санал зөвлөмж гаргах,
- 2.3 Жижиг, дунд бизнесийг дэмжих бодлого гарган ажиллах,
- 2.4 Бичил, жижиг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэнг үндэсний хэмжээнд зохион байгуулах,
- 2.5 Шинжлэх ухаан ба бизнесийн салбарыг холбох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хамтын ажиллагааны загварыг гаргаж турших,
- 2.6 Аж ахуйн нэгжүүд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

2.7 Том аж ахуйн нэгжүүдийн зүгээс жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг худалдан авалт, хамтын ажиллагаагаар дэмжин ажиллах санал санаачилгуудыг дэмжин ажиллах,

3. Экспортыг нэмэгдүүлэх, экспортын бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх

- 3.1 Экспортын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх,
- 3.2 Экспорт хийх боломжтой улсууд болон бүтээгдэхүүний зах зээл, хууль эрх зүйн орчны судалгаа хийх, үр дүнг танилцуулах уулзалт зохион байгуулах,
- 3.3 Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн экспорт хийх үйл явц, тулгардаг асуудлыг тодруулах судалгаа явуулж, дүн шинжилгээ хийх,
- 3.4 Европын Холбооны "Монгол Улсад Гадаад Худалдааг Хөгжүүлэх" (ITDM) төслийг хэрэгжүүлэх, төслийн хүрээнд кластеруудад зориулсан сургалт зохион байгуулах, худалдааны мэдээллийн төвийг байгуулах, Европын улсуудад зохион байгуулагдах үзэсгэлэнгүүдэд аж ахуйн нэгжүүдийн оролцоог хангах, дэмжлэг үзүүлэх,
- 3.5 Европын холбооны Switch-Asia хөтөлбөрийн хүрээнд "Тогтвортой сарлагийн арьс" төслийг хэрэгжүүлэх, сарлагийн арьс ширийг бэлтгэх сайн туршлага нэвтрүүлэх, сургалтууд зохион байгуулах,
- 3.6 Бизнес айлчлал, хоёр талт бизнес форум, хөрөнгө оруулагчдын уулзалтууд ба бизнес айлчлалыг дотоод, гадаадад зохион байгуулах,
- 3.7 БНХАУ, ОХУ, Япон, Солонгос, Тайван, ХБНГУ, Канад, АНУ зэрэг улсуудад гадаад үзэсгэлэн зохион байгуулах, үзэсгэлэнд бизнес групп оролцуулах,
- 3.8 Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн худалдааны хэрэгслүүдийг бизнес эрхлэгчдэд таниулах сургагч нарыг бэлтгэх,
- 3.9 Дэлхийн ЭКСПО - 2025 Осака Кансай бэлтгэл ажлыг хангах (ажлын хэсгийг байгуулах, Монголын павильоны ерөнхий концепци гаргах, павильоны дизайн гаргах, павильоны дотор тоглогдох аудио дуу, видео дүрс, зураглал, зураг зэрэг контентуудыг бэлтгэх, үндэсний үйлдвэрийн барааг сонгох, ачуулах)

4. МҮХАҮТ-аас үзүүлдэг ажил үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах

- 4.1 "Гарал үүслийн гэрчилгээ"-г цахимжуулах төслийг Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлэх, цахим гарал үүслийн гэрчилгээний веб хуудсыг ашиглалтанд оруулах, блокчейнд байршуулах,
- 4.2 Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтыг хийх, оюуны өмчийн мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээх, сурталчлах,
- 4.3 Экспертизийн үйлчилгээ үзүүлэх, Хөндлөнгийн шинжээчээр ажиллах,
- 4.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын хүсэлт судлах, дүгнэлт гаргах,
- 4.5 Арбитрын хэргүүдийг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах, арбитрын үйл ажиллагааны ойлголт өгөх төрөл бүрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах, арбитрын хамтын ажиллагааг өргөжүүлэх, цахим арбитрын төслийг хэрэгжүүлэх,

- 4.6 Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)-тай хамтарсан төслийн хүрээнд "Trade Mongolia" цахим хуудсыг хөгжүүлэх, МҮХАҮТ-ын дотоод цахим системийг шинэчлэх,
- 4.7 Эдийн засаг, бизнесийн орчны талаарх чухал мэдээ, мэдээллүүдийг аж ахуйн нэгжүүдэд тогтмол хүргэдэг болох,
- 4.8 Эдийн засаг, бизнес болон экспортын бүтээгдэхүүн, зах зээлийн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан, хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах,
- 4.9 Монголын бизнесийн орчны судалгаа-2023 судалгааны дэлгэрэнгүй тайлан бэлтгэн гаргах, аймаг бүрээр судалгааны тайланг гаргах, судалгааны үр дүнгээр салбар бүрээр зөвлөмж, танилцуулга постер бэлтгэн олон нийтэд мэдээлэх,
- 4.10 Бизнес итгэлийн индекс, Хүнд суртлын индексийн судалгааг явуулж, тайлан гаргаж үр дүнг мэдээлэх,
- 4.11 Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO)-тай хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд Судалгааны институтийн судалгааны платформыг хөгжүүлэх, судалгааны асуулга авах, өгөдлийг шинжлэх үйл явцыг цахимжуулах,
- 4.12 Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх чадавхыг сайжруулах, тэдгээрийн хэрэгцээнд нийцсэн сургалтууд зохион байгуулах,
- 4.13 Гүйцэтгэх удирдлага, менежерүүдэд зориулсан ур чадвар, хандлагын сургалтууд зохион байгуулах,
- 4.14 Жижиг дунд бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй сургалтуудыг онлайн платформд байршуулах,
- 4.15 Мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх тогтолцоог шинэчлэх, хосмог тогтолцоог хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах,
- 4.16 Оны шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах, ТОП 100 ААН-ийг эрэмбэлэх, үндэсний чанарын шалгаруулалтыг хийх зэрэг шалгаруулалтын арга хэмжээнүүдийн арга, аргачлалыг сайжруулах,
- 4.17 Дотоодод үзэсгэлэнгүүд зохион байгуулах, салбар танхимуудын үзэсгэлэн зохион байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

5. МҮХАҮТ-ын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт хамрагдах, төсөл хөтөлбөрийн санхүүжилт олох чиглэлээр санаачилга гарган ажиллах

- 5.1 МҮХАҮТ-ын гишүүнчлэлтэй Ази, Номхон далайн орнуудын ХАҮТ-уудын нэгдсэн холбоо (CACCI), Азийн худалдааг дэмжих форум зэрэг (ATPF) олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, бусад улсуудын Танхим, Холбоодтой хамтран ажиллах,
- 5.2 Монгол, ОХУ, БНХАУ-ын ХАҮТ-ын 17 дугаар нэгдсэн чуулганыг БНХАУ-д зохион байгуулах,
- 5.3 Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Олон улсын байгууллагууд болон дипломат төлөөлөгчийн газрууд, Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх,

6. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгжүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, бизнесийн ёс зүйн мэдлэг туршлагыг түгээх, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх

- 6.1 НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (Global Compact)-г сурталчлан таниулах, сүлжээнд Монгол улсын оролцоог нэмэгдүүлэх,
- 6.2 Бизнесийн ёс зүйн төвийн үйл ажиллагааг явуулах, төвийн цаашдын стратегийг тодорхойлох, бизнесийн ёс зүйн сургалт, арга хэмжээг зохион байгуулах,
- 6.3 Олон улсын Худалдааны төвийн (ITC)-ийн “She trades Hub Mongolia” үйл ажиллагааг явуулах, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг бүртгэх, мерчандайз бүтээгдэхүүнүүдийг бий болгох, эмэгтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах
- 6.4 Азийн сантай хамтарсан “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн B2B платформыг хөгжүүлэх” төслийн хүрээнд цахим худалдаа, маркетинг, хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, ментор хийх,
- 6.5 Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (IOM)-ын төслийн хүрээнд 18-35 насны эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах, зөвлөгөө өгөх
- 6.6 Эмэгтэй бизнес эрхлэгчдэд санхүүгийн эх үүсвэрийг өргөжүүлэх болон бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлах, олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах боломж олгох зорилготой "Women Owned" тохирлын тэмдгийг сурталчлах, эмэгтэй бизнес эрхлэгчдийг хамруулах